

25. Аав аа, бид Мароккогийн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд болон сайн сайхны төлөө залбирч байна. Тэдэнд чанартай сайн эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжийг нээж өгөөч. (3 Иохан 1:2)

26. Эзэн минь, бид Ойрхи Дорнодын сүм чуулгануудын залуу эмэгтэйчүүдийн сүнслэг байдал, оюун ухаан, бие махбодын хамгаалалтын төлөө залбирч байна. Тэд итгэлийн амьдралдаа тууштай байх болтугай. (2Тессалоник 3:3)

27. Туркменистанд эмэгтэйчүүдийн үйлдлийг шударга бусаар хязгаарласан ёс жаяг болон хуулиуд олон байна. Эзэн минь, удирдагчид эмэгтэйчүүдийг ойлгож, илүү их эрх чөлөөг өгөхийн тулд тэдний зүрх сэтгэлд Та ажиллаач. (Лук 4:18)

28. Бурхан минь, Хойд Африкийн залуучуудын дунд ёс суртахуунгүй байдал ихсэж байгаа өнөө үед эмэгтэйчүүд Таны үнэн дотор итгэлтэй, сүнслэг харилцааны үнэ цэнийг олж харахад Та туслаач. (Сургаалт үгс 3:3)

29. Эзэн минь, Хойд Киприйн шинэ удирдагч болон "Найдвар доторх эмэгтэйчүүд" TWR-н баг тэнд байгаа залуу, үл итгэгч эмэгтэйчүүдэд үйлчлэхээр эрэлхийлж байгаа энэ үед Та тэднийг ерөөж, хамгаалах болтугай. (Тооллого 6:24-26)

30. Аав аа, Туркэд гэртээ үр хүүхэд, гэр бүлээ асарч байгаа ганцаардсан эмэгтэйчүүдийг тайвшруулж, хүчирхэгжүүлэх болтугай. (Дэд хууль 31:6)

## Монголын төлөө залбирах сэдвүүд

1. Монгол улсыг удирдаж байгаа засгийн газрын гишүүд шударгаар ард түмнээ хайрлаж, Бурханаас эмээхийн төлөө

2. Монгол улсын хууль тогтоомж шударгаар үйлчилж, Монгол улс эдийн засгийн хямралаас гарахын төлөө.

3. Хиймэл шүтээн шүтэж харанхуй дотор алхаж байгаа хүмүүс Бурханыг таньж мэдэн гэм нүгэлээсээ эргэж гэмшихийн төлөө

4. Монголын гэр бүлүүд Эзэнтэй хамт алхдаг байхын төлөө. Гэр бүлүүд дотор өсөж торниж байгаа хүүхдүүдэд эцэг эхийн нөлөө зөв байхын төлөө

5. Монгол эрчүүд архинд донтон, гэр бүлдээ үл хүндлүүлэх байдал их байна. Эзэн Монгол эрчүүдийг өөрчлөн, гэр бүлийнхээ тэргүүн байж, гэр бүлдээ хайрлагдсан хүндлэгдсэн аавууд байхын төлөө

6. Монголын залуу гэр бүлүүд маш их салж байна. Олон хүүхдүүд өнчирч байна. Тиймээс залуучууд сонголтоо зөв хийж, үх хүүхдээ өнчрүүлэхгүй байхын төлөө

7. Монгол чуулганууд сэргээгдэж, сайн мэдээ орон даяар тунхаглагдаж, улс орноороо Эзэн рүү хандан залбирдаг, Эзэнээс эмээдэг ард түмэн болохын төлөө



## Найдвартай эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанлиг 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023. 9.

## CAMINA бүс нутгийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал

CAMENA гэдэг нь TWR-ийн үүсгэсэн товчлол бөгөөд Төв Ази, Ойрхи Дорнод, Хойд Африкийн бүс нутгийг хэлдэг. Курд ард түмэн бол өөрийн гэсэн улс орон, төргүй дэлхийн хамгийн том угсаатны нэг юм. Дэлхий даяар 30-40 сая курд байдгийн ихэнх нь Турк, Иран, Ирак, Сирийг амьдардаг бөгөөд Курдистанд амьдардаг.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다

## TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층  
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, манай Фарсид шинээр бүтээж "Найдвар доторх эмэгтэйчүүд" цуврал нэвтрүүлэгийг Иран, Турк болон бусад орноос дүрвэж ирсэн эмэгтэйчүүд сонсож, Есүст итгэх итгэх болтугай. (Дуулал 130:7)

2. Аав аа, Каракалпакстаны эмэгтэйчүүд гэр бүл салалт, ажилгүйдэл, өөрийн үнэлэмжгүй, боловсролдутмаг байдал зэргээс болж сэтгэл зүйн гутралд орж, айдаст автаж байна. Тэдгээр эмэгтэйчүүд Танаас ирэх итгэл найдвар, үнэ цэнийг олох болтугай. (Дуулал 143:7-8)

3. Бурхан минь, сүүлийн жилүүдэд хаагдахаас өөр аргагүй байдалд орсон Хойд Африкийн чуулганууд Христийн нөхөрлөл болон сүнслэг халамжаар хангагдах болтугай. (Матай 4:4)

4. Израйлийн Тель-Авив төвд хуучин ЗХУ-аас ирсэн цагаачид биеэ үнэлэх нь их байна. Эзэн минь, эдгээр эмэгтэйчүүдэд гарах гарцыг зааж өгөөч. (Дуулал 107:28)

5. Эзэн, бид Арабын "Найдвар доторх эмэгтэйчүүд" хөтөлбөрийн төлөө Таныг талархан магтъя. Тэд сонсогчдоо зөвлөгөө өгч, тэднийг дагалдуулж байгаад талархаж байна. (Ром 10:14)

6. Эзэн минь ээ, Туркэд өнгөрсөн жил инфляци 85 хувьд хүрсэн тул үүнээс шалтгаалан түрээсээ төлж чадахгүй, амьдрах найдваргүй болж байгаа хүмүүсийн төлөө бид санаа нэгдэн залбирч байна. (Ром 15:13)

7. Бурхан минь, Хойд Киприйн өвдөж, шархалсан эмэгтэйчүүдэд Та туслаач. Тэд Есүсээс ирэх итгэл найдвар, эдгэрэлийг хүлээн авах болтугай. (Дуулал 107:13-16)

8. Тэнгэрлэг Аав минь, бид Египет дэх эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, хамгаалалтыг Танд өргөн залбирч байна. Та тэднийг хор хөнөөлөөс хамгаалж, амар тайванг дүүргэж өгөөч. (Дуулал 91:11-12)

9. Дайнд өртөж буй Йемен, Суданы эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Үр хүүхдүүдээ ганцаараа өсгөж, хоолтой хонуулах гэж хичээж байгаа ээжүүдийг Та хамгаалах болтугай. (Дуулал 46:1)

10. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй Узбекистаны эмэгтэйчүүдийг Та хамгаалж, эдгээгээч. Хүчирхийлэл үйлдэж буй нэгний зүрх сэтгэлийг Та өөрчлөх болтугай. (Исаиа 41:10)

11. Эзэн минь, Тажикистаны эрчүүд ажил хийхийн тулд Орос руу цагаачилж явахгүйгээр эх орондоо хийх ажлаар хангагдах болтугай. Тэнд хууль бусаар явсанаас болж шоронд хоригдож байна. Тиймээс Та ажлын байраар хангаж өгөх болтугай. (Дуулал 90:17)



12. Бурхан минь, Хойд Кипрт казино, эмсийн хүрээлэнд байдаг хүний наймааны хохирогч болсон эмэгтэйчүүдийг хамгаалж өгөөч. Хүчээр биеийг нь үнэлүүлж байгаа нөхцөл байдлаас гарах арга замыг Та заагаач (Дуулал 82:3)

13. Аав аа, Турк, Сирийн газар хөдлөлтөд өртсөн хүмүүст Та Өөрийгөө илчлэн харуулаач. Тэд Есүсийг таньж, Түүнийг хүлээн авч, Түүнд итгэх итгэх болтугай. (Исаиа 54:10)

14. Эзэн минь, Иорданы эмэгтэйчүүдэд боловсролоо дээшлүүлэх боломжийг өгөөч хэмээн Тан руу хандан залбирч байна. Тэднийг нийгэмд хувь нэмрээ оруулах мэдлэг, ур чадварыг сайн эзэмшихэд нь Та туслаач. (Сургаалт үгс 1:5)

15. Хойд Африкийн хүмүүст сайн мэдээг хүргэхийн тулд амь насаа эрсдэлд оруулж буй итгэлийн дуудлагыг авсан хүмүүст Та хамгаалалт болон урам зоригийг өгөх болтугай. (Дуулал 23:4)

16. Бурхан минь ээ, Израйлийн эмэгтэйчүүд Есүс Христийг Эзэн, Аврагч болгон хүлээн авахын тулд Та тэдний нүд, зүрх сэтгэлийг нээгээч. (Марк 14:61- 62)

17. Эзэн минь, Төв Азийн эмэгтэйчүүдэд өөрсөдөө болон гэр бүлдээ ашигтай бизнесийг эхлүүлэх бүх боломжийг нээж өгөөч. (Сургаалт үгс 31:18)

18. Бурхан минь, бид Сири дэх эмэгтэйчүүдийн эрх чөлөө, хүний эрх хамгаалагдахын төлөө залбирч байна. Христ итгэлт хэвлэл мэдээлэлийн хэрэглсэл тэдэнд Таны эдгэрэл болон сэргэлтийн үнэнийг хүргэх болтугай. (Исаиа. 61:1)

19. Ааваа, Израйлийн эмэгтэйчүүдэд ямарваа бэрхшээлийг давах мөн бусдад найдварын эх сурвалж болох хүч болон урам зоригийг өгөөч. (Иошуа 1:9)

20. Киргизийн ядуус эдийн засгийн хямрал, ажилгүйдэлд нэрвэгдэж байна. Эзэн минь, засгийн газраас хоол хүнс, эмнэлгийн тусламж үйлчилгээгээр тэднийг дэмжих болтугай. (Иаков 2:15-16)

21. Эзэн минь, Хойд Африкт үйлчилж байгаа манай багуудад өөр өөр амьдралтай хүмүүст зориулан программаа хэрхэн бэлтгэн хүргэх, үйлчлэх мэргэн ухааныг өгөөч. (Иаков 3:17)

22. Аав аа, саяхан эхэлсэн Ойрхи Дорнодын Курдын жижиг бүлгийн нөхөрлөлийг бэхжүүлж өгөөч. Бүлгийн удирдагчид анхаарал татсан сэдвүүдээр хэлэлцүүлэг хийх мэргэн ухаан, урам зоригийг Та өгөөч. (Иаков 1:5)

23. Бурхан минь, нийгмийн болон санхүүгийн дарамтанд тэмцэж буй Хойд Африкийн эмэгтэйчүүд, гэр бүлүүдийн төлөө бид залбирч байна. Тэдэнд хэрхэн амьдрах мэргэн ухааныг өгөөч. (Сургаалт үгс 21:5)

24. Бурхан минь, өнчин болон гэр бүл нь хайхардаггүй, хараа хяналтгүй хүүхдүүдэд Узбекистаны Христэд итгэлтэд зүрх сэтгэл болон орон гэрийнхээ үүд нээх болтугай. (Иов 29:12)